



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН МЭНД ЦОЛМОН ӨЭМТ-ИЙН 2025 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: НТАГ-2026/192/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч. Болд Утас:70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Санхүү-Нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х. Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я. Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn Аудитор: Т. Мөнхцацрал Утас: 325093 Цахим хаяг: munkhtsatsralt@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ашид баланс аудит ХХК-ийн захирал: Л.Майцэцэг Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13

№

890

танай

-ны №

-т

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРИЙН МЭНД
ЦОЛМОН ӨЭМТ-ИЙН ДАРГА
Ц.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мэнд цолмон ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мэнд цолмон ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан эрүүл мэндийн даатгалын сангаас иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 895.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тус төв нь Health.gov.mn программыг ӨЭМТ-ийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэн, ӨЭМТ-ийн дарга, их эмч, сувилагч, бүртгэл мэдээллийн ажилтан зэрэг нийт 20 албан хаагч байнгын ашиглаж байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мэнд цолмон ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/47

захирамжаар 89.7 хувь, ЭМДЕГ-аас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 94.1 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ХӨРӨНГИЙН ДҮН		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,423,948.74	1,664,869.54
1.1.2	Авлага	69,350,865.59	11,029,921.52
1.1.6	Бараа материал	55,571,790.30	62,810,909.29
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	126,346,604.63	75,505,700.35
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	134,642,183.56	111,609,367.44
1.2.2	Биет хөрөнгө	142,999.84	-
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	134,785,183.40	111,609,367.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	261,131,788.03	187,115,067.79
2	Өр төлбөр ба эздийн өмч		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Дансны өглөг	684,839.58	715,000.00
2.2	Өр төлбөрийн дүн	684,839.58	715,000.00
2.3	Эздийн өмч	55,379,883.21	55,379,883.21
2.3.1	Өмч-төрийн	149,866,191.32	149,866,191.32
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	11,791,870.00	11,791,870.00
2.3.9	Хуримтлагдсан үр дүн	105,702,035.38	98,788,887.13
2.3.10	Тайлант үеийн үр дүн	(6,913,148.25)	(74,046,880.66)
2.3.11	Эздийн өмчийн дүн	260,446,948.45	186,400,067.79
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ӨМЧ	261,131,788.03	187,115,067.79

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого	855,904,607.24	836,878,331.90
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
3	Нийт ашиг /алдагдал/	855,904,607.24	836,878,331.90
5	Хүүгийн орлого	107,855.51	228,084.29
6	Бусад орлого	17,567,287.79	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	880,492,898.79	911,153,296.85
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(6,913,148.25)	(74,046,880.66)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(6,913,148.25)	(74,046,880.66)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал)	(6,913,148.25)	(74,046,880.66)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
27	Нийт орлогын дүн	(6,913,148.25)	(74,046,880.66)
28	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	816,989,893.79	896,199,275.97
1.1.5	Татаас санхүүжилтийн орлого	815,805,422.47	895,199,275.97
1.1.6	Бусад орлого	1,184,471.32	- 1,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	814,098,212.59	882,873,836.46
1.2.1	Ажиллагсад төлсөн	629,449,102.35	691,010,320.73
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	84,340,258.68	80,498,116.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	55,115,848.51	57,918,260.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	10,626,460.26	12,220,464.94
1.2.9	Бусад мөнгөн зардал	34,566,542.79	41,226,674.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,891,681.20	13,325,439.51
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,742,144.49)	(13,084,518.71)
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	107,855.51	228,084.29
2.1.6	Хүүгийн орлого	107,855.51	228,084.29
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,850,000.00	13,312,603.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,850,000.00	13,312,603.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	1,149,536.71	240,920.80
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	274,412.03	1,423,948.74
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,423,948.74	1,664,869.54

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	149,866,191.32	11,791,870.00	105,702,035.38	267,360,096.70
Залруулсан үлдэгдэл	149,866,191.32	11,791,870.00	105,702,035.38	267,360,096.70
Тайлант үеийн ашиг (алдагдал)			(6,913,148.25)	(6,913,148.25)
2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	149,866,191.32	11,791,870.00	98,788,887.13	260,446,948.45
Залруулсан үлдэгдэл	149,866,191.32	11,791,870.00	98,788,887.13	260,446,948.45

Тайлант үеийн ашиг (алдагдал)			(74,046,880.66)	(74,046,880.66)
2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	149,866,191.32	11,791,870.00	24,742,006.47	186,400,067.79

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мэндцолмон ӨЭМТ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.2-т “Өрхийн эрүүл мэндийн төв нь хот, суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна” гэж заасны дагуу эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг иргэн бүрд, аюулгүй, тэгш, хүртээмжтэй хүргэх үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мэндцолмон ӨЭМТ нь “Эмнэлгийн тусламж, үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй үзүүлэх, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлох, шаардлагатай лавлагаа, тусламжийг цаг алдалгүй зохион байгуулах, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах” эрхэм зорилгын хүрээнд тайланд онд “Үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үзүүлэх” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант онд нийт үзлэгийн тоо 42,415 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 13,963 гэрийн идэвхтэй эргэлт 7,854 амбулаторийн үзлэг 17,983 идэвхтэй хяналт 1,969 гэрийн дуудлагаар үзсэн 646 хүнд анхан шатны тусламж үйлчилгээг хүргэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Нөхөрлөлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль, Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм болон бусад холбогдох хууль, тогтоомж, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- ЭМДҮЗ-ийн 2025 оны 11 дүгээр сард “Эрүүл мэндийн даатгалын 2025 оны төсвийн хуваарийг шинэчлэн тогтоох тухай”;
- ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 04 дүгээр тогтоол “жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга журам, шинэчлэн тогтоох тухай”;
- ЭМС-ын 2025 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 1-352 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн байгууллагуудад нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж, нийтлэх, шинэчлэх, хяналт тавих журам”;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт шалгуур үзүүлэлтийн дагуу хийгдсэн байна.

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Дотоод аудитын албанаас 2 жилд нэг удаа хяналт шалгалт хийдэг бөгөөд тайлант онд хийгдсэн байна. ӨЭМТ-ийн дарга батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээг хянаж баталгаажуулснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Оны эхний ЭМДЕГ-ын санхүүжилтийн авлагад ХХОАТ-ын авлагыг бүртгэсэн.	1	1,104.1			1	1,104.1	1	1,104.1				
Тайлант хугацаанд ЭМДЕГ-ын санхүүжилтийн авлага 9,925.8 мянган төгрөгийг бусад авлага дансанд бүртгэсэн байна.	1	9,925.8			1	9,925.8	1	9,925.8				
Чингэлтэй дүүргийн тамгын газраас гуравласан гэрээний дагуу ахмадын эмчийн цалин, ашиглалтын зардлын 50 хувийн орлого болох дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид олгосон 46,770.9 мянган төгрөгийн орлогыг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн орлогод бүртгэсэн	1	46,770.9			1	46,770.9	1	46,770.9				
Дүн	3	57,800.7			3	57,800.7	3	57,800.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тавилга эд хогшил дансанд 3,534.1 мянган төгрөгийн эмнэлгийн хэрэгсэл, багаж, хангамжийн зүйлсийг бүртгэсэн	1	3,534.1						1	3,534.1
Санхүүгийн программ "aculus" нь шаардлага хангахгүй, хөгжүүлэлт, шинэчлэлтийг тогтмол хийлгэдэггүй байна. Тухайлбал оны эхний үлдэгдэл буруу татагдах, стауст хөрвүүлэхэд алдаа гарч байна.	1							1	